

БИОЛОГИЙН ИДЭВХТ ХҮНСНИЙ НЭМЭЛТ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ЭМТ БОДИСЫГ ЯЛГАХ НЬ

Чөн хун мэй¹, Э.Энхсүрэн², Чан чун¹, Жин Уэн Жиэ¹, М.Мөнхцэцэг², Ван шу лан¹

¹Өвөр Монголын Үндэстний Их Сургууль,

²Эм зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

ABSTRACT: Biologically active supplement is natural health care food with no harm to the human body, rich in various vitamins and prevent us from disease. Aim of medicine is prevent from disease, treatment, diagnosis and to be clear such as indications, use, dose, main active substance, regulation of physiology. In This article, related knowledge of medicine and health care food, to clarify the relationship between health care food and medicine, which provide evidence for how to use health care food and medicine correctly. Biologically active supplements have many effects such as protects human body, improve health, prevent from disease etc, but the effects nature is not same. So biologically active supplements are not used as substitute to medicine.

Key words: Biologically active supplement; medicine; difference.

Үндэслэл: Биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүн (БИХНБ) бол цэвэр байгалийн гаралтай хүний биед хор хөнөөлгүй ургамлаар эх материалаа болгож төрөл бүрийн эрдэс, бичил элемент, амин дэмээр баялаг өвчнөөс урьдчилан сэргийлэх нэг төрлийн онцгой эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй идээ болно. БИХНБ нь хүний биеийн физиологийн үйл ажиллагааг тохируулж, биеийн дархлаа суларсан, ядарч доройтсон хүмүүсийг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой. Хятад улсын эрүүл хамгаалалын яамнаас хянан зөвшөөрсөн БИХНБ эрүүл мэндийг дэмжих үйлдлийг нь нийт 27 зүйл хувааж тогтоосон байдаг[1].

Эмт бодис гэдэг нь өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, оношлох зорилготой ба хүний бие махбодийн физиологийн үйл ажиллагааг тохируулахын зэрэгцээ хэрэглэх заалт, хэрэглэх арга, тун хэмжээ, үйлчлэх бодис зэрэг нь тодорхой заагдсан байдаг. Үүнд: Хятад эмийн материал, Хятад хэрчмэл эм, Хятад эм найрлага, түүхий эд, химийн эм, бактерийн эсрэг эм, биологийн идэвхит бодисоос гаргаж авсан химийн эмт бодис, цацраг идэвхит эмт бодис, цусны сийвэн, хижгийн тарилга, цусаар найруулсан эмт бодис болон оношлох эмт бодис багтана[2].

Сүүлийн үед эмт бодисын хэрэгцээ шаардлагын хирээр биологийн өндөр идэвхитэй эмт бодисын хэрэглээ өссөн, ард иргэдийн дунд өөрөө дур мэдэн эм хэрэглэх нь

түгээмэл болсон, эмийг хэрхэн зөв зохистой хэрэглэх талаар мэдээлэл дутмаг байна. Мөн БИХНБ-ийг эмийн чанартай ямар нэгэн эрхтэн системийн өвчин эмгэгийг эмчлэх зориулалттай байдаг гэсэн өрөөсгөл ойлголт хүн амын дунд цөөнгүй байгаа ба БИХНБ-ий талаар зөв зохистой мэдлэг тааруу байгаагаас уг сэдвийг сонгон авч эмт бодис ба БИХНБ-ий талаар мэдээ материалыг эмхэтгэн цуглуулж БИХНБ болон эмт бодисын харьцаа холбоог нягтлан тодорхойлж, эдгээр бодисыг зөв зохистой хэрэглэхэд шаардлагатай баримт нотолгоог гаргасан байна.

1. БИХНБ болон эмт бодисын ялгаа

1.1. Баримтлах дүрэм журам нь адил бус. БИХНБ нь Хятадын эрүүл хамгааллын яамнаас тогтоосон “БИХНБ хэрэглэх арга”-ыг баримтална. Эмт бодис нь Хятад улсын идээ ундаа болон эмт бодисын хянан хамаарах товчооноос тогтоосон “ БНХАУ-ын эмийн тухай хууль”-ийг баримтална.

БИХНБ-ийг үйлдвэрлэхэд “БИХНБ үйлдвэрлэлийн чанарын стандарт”, (GMP) –ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэх хэрэгтэй. Эмт бодис үйлдвэрлэх бол заавал “Эмийн үйлдвэрлэлийн чанарын стандарт” (GMP)-ын шаардлага хангасан эмийн үйлдвэрт үйлдвэрлэх хэрэгтэй.

1.2. Хэрэглэх заалт болон зориулалт нь өөр өөр. БИХНБ нь цэвэр байгалийн гаралтай хүний биед хоргүй ургамлаар эх материалаа

болгож төрөл бүрийн эрдэс, бичил бодис, амин дэмээр баяжуулсан, хүний биед цочмог болон удаан чанартай хор хөнөөлгүй байж өвчнөөс урьдчилан сэргийлж эрүүл мэндийг хамгаалахад хэрэглэнэ. Хэрэглэх зориулалт нь хүнсэнд нэмэлт болгох ерөнхий БИХНБ –ээс гадна, хүүхэд, ахмад настан, эр, эм хүйстэн зэрэг тодорхой бүлгүүдэд тусгайлан зориулж бүтээсэн байдаг.

Эмт бодис бол тодорхой нэг өвчний үед тогтоосон тун хэмжээгээр тухайн хүний нас биеийн онцлог өвчний байдлаас хамааран хэрэглэдэг. Аливаа өвчин эмгэгийг анагаах зорилгоор эмчилгээний тунгаар эмийг хэрэглэхэд өвчтөнд ашиг тустай эмчилгээний үйлдэл үзүүлэхийн зэрэгцээ заримдаа сөрөг тааламжгүй бүр хортой нөлөө үзүүлэх явдал байдаг. Эмт бодис нь хүний болон мал амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалттай бүтээгдсэн.

1.3. Кодын дугаар нь адилгүй

БИХНБ бол 2004 оноос өмнө Хятадын эрүүл хамгааллын яамнаас хянан зөвшөөрч үсгийн дугаар олгох болсон байна. Улсын дотоодод үйлдвэрлэсэн эрүүл мэндийг дэмжих БИХНБ-ий кодын дугаарыг G20** -иар тэмдэглэж, гадаадаас оруулж ирсэн БИХНБ-ий кодын дугаарыг J20** -иар тус тус тэмдэглэнэ.

Хятад улсын идээ ундаа болон эмт бодисын хянан хамаарах товчооноос зөвшөөрч эмт бодисын кодын дугаар олгох бөгөөд үсгийн дугаарын илэрхийх арга: Улсын эмийн үсгийн дугаар H(эсвэл Z.S.J)+ он сар 4 оронтой тоо+ дарааллыг илтгэсэн 4 оронтой тоо. Үүнд : H - химийн эмт бодис, Z - Хятад эмт бодис, S - биологийн эмт бодис, J - гадаадаас оруулсан эмт бодисыг төлөөлнө.

1.4. Тодорхойлолтын тухай дүрэм тогтоол нь адилгүй.

“БНХАУ-ын эмийн тухай хууль”-д эмт бодисын тодорхойлолтын тухай дүрмийг тогтоосон бөгөөд Хятад эм, байгалийн эм, химийн эм, биологийн эмийн тодорхойлолтын агуулга, шаардлагын тухай тус тусад нь дүрэмчлэн баримтлах зарчмыг тогтоосон байдаг. Иймээс заавал дүрэм тогтоолыг үндэслэн нарийн тодорхой бичиж, улсын эрүүл мэндийн газраас зөвшөөрсөн байх

хэрэгтэй. Гэтэл БИХНБ–ий тодорхойлолт нь эмт бодисын тодорхойлолттой харьцуулбал бага байдаг. БИХНБ-ий тодорхойлолтын агуулга нь голдуу эрүүл мэндийг дэмжих үйлдэл, хэрэглэх заалт, уух арга ба хэмжээ, гол бүрэлдэхүүний нэр, найрлага, хадгалах арга, БИХНБ-ий кодын дугаар, тэмдэг, хүчинтэй хугацаа зэрэг багтана.

1.5. Шингээлтийн зам нь адилгүй

БИХНБ-ийг голдуу ууж хэрэглэх ба ходоод гэдэсний замаар шингээнэ. Эмт бодисын найрлагын хэлбэр нь олон зүйл байдгаас эм өгөх арга нь ч олон, шингээлтийн зам нь мөн олон зүйл байдаг. Жишээлбэл: үрэл эмийг ууж хэрэглэх учраас ходоодоор дамжин шимэгдэн үйлдэл үзүүлж, тарилгын эм бол судсаар тарьдагаас цусаар дамжин шимэгдэж, наалт эм бол арьсаар дамжин шимэгдэж үйлдэл үзүүлнэ.

1.6. Сурталчилгааны хувьд мөн адилгүй

Тусгай мэргэжилийн чанартай, анагаах ухааны сонин сэтгүүл, кино болон олон нийтийн телевиз нэвтрүүлэгт зар сурталчилгаа хийж болно. БИХНБ-ий хувьд зар сурталчилгаа хийхдээ өвчнийг засах мэт ухуулга хийж болохгүй бөгөөд Хятадын эрүүл хамгааллын яамнаас хянан зөвшөөрсөн 27 чадлаас хэтэрч болохгүй.

Анхаарах зүйл

Эмт бодисыг хэрэглэх үед өвчний байдлыг үндэслэн эмийн сангаас худалдан авч тодорхойлолтын дагуу эм хэрэглэх буюу эмчийн заалтаар эм хэрэглэх хэрэгтэй. БИХНБ-ийг хэрэгцээт шаардлагатай үед үндэслэн хэрэглэх бөгөөд хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлэх хэрэгтэй. Үүнээс гадна эмт бодис ч тэр БИХНБ нь ч тэр үйлдвэрлэсэн хугацаа, эмийн хүчинтэй хугацаа зэргийг анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт:

Тус өгүүллийг дүгнэн хэлэхэд эмт бодис бол өвчнийг анагаан засах үйлдэлтэй ба өвчтэй биеийг эрүүлжүүлж байдаг. БИХНБ бол өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлдэлтэй байж бие махбодийг хамгаалах бөгөөд бие эрүүл байдлаа алдах үед хэрэглэхэд биеийн эрүүл мэндийг сайжруулахад туслана. Ерөнхийлөн хэлбэл эмт бодис ба БИХНБ нь биеийн эрүүл мэндэд туслах боловч эдгээрийн мөн чанарын үйлдэл нь адилгүй. Иймээс БИХНБ-ээр эмт бодисыг орлуулан өвчнийг анагаан засаж болохгүй

Ном зүй:

- 1.国家食品药品监督管理局，国家食品药品监督管理局令第19号；
保健食品注册管理办法（试行）[S] 民药品 管理办法；[S]
- 2.国家食品药品监督管理局，中华人